



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 413

Улаанбаатар хот

Г “Гендекс” ХХК-ийн андеррайтерийн 7
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалт болон Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.2.8, 8.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Гендекс” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2010 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

2. “Гендекс” ХХК-ийн андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авах, архивт шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН